



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөн, Г.жорлус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2023. 07. 24 № 108
такой -ны №

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Л.САНЖИЙЖАМЦ ТАНАА

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсрал . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C. Gossamer

Ташкент, 1980 йил
10.10.1980

1. Causes

1043. 02. 02

002031350

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2023/08/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2023 он

Санхүү-нийцлийн хэлтсийн дарга,
аудитын менежер: З.Мөнхбаяр

Утас: 327734 Цахим хаяг:
munkhbayar@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ундармаа

Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn

Аудитор: Д.Нарантуяа

Утас: 325093 Цахим хаяг: narantuyad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ	5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.5.3 Нэмэлт төсөв	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Албан шаардлага	22
5.2 Зөвлөмж	23

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
БХД	Багахангай дүүрэг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
УИХ	Улсын их хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НТГ	Нийтийн тээврийн газар
УБ	Улаанбаатар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г.ворлус, 5 дивхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ua@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023. 02. 24 № 409
танай _____-ны № _____-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэхбайгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 56,112.2 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд зөвлөхийн орон тоо илүү ажиллуулсан, 11 дүгээр сард 39 ажилтанд нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний шагнал урамшууллыг хавтгайруулан олгож төсвийг үрэлгэн зарцуулсан, Засаг даргын нөөц хөрөнгөөс урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжтой зардлыг санхүүжүүлсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 143 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	87,480,976.22	95,861,133.74
33	АВЛАГА	1,197,990.50	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	580,880.00	00.00
335	Бусад авлага	617,110.50	00.00
3351	Байгууллагаас авах авлага	617,110.50	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	86,282,985.72	95,861,133.74
354	Хангамжийн материал	86,282,985.72	95,861,133.74
35410	Бичиг хэргийн материал	10,029,025.00	11,198,815.00
35470	Бусад хангамжийн материал	76,253,960.72	84,662,318.74
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,524,906,408.37	7,734,213,682.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,524,906,408.37	7,734,213,682.63
392	Биет хөрөнгө	6,515,133,308.37	7,649,527,882.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,276,182,153.33	7,316,182,153.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,586,272,572.84	-2,054,006,568.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	513,179,835.00	481,238,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-123,249,835.07	-159,788,700.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	363,161,737.11	192,465,256.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-298,814,507.76	-59,438,577.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,303,081.35	106,213,620.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-99,850,581.46	-51,623,357.55
39214	Бусад үндсэн хөрөнгө	410,654,990.07	2,038,924,835.22
39215	Хуримтлагдсан элэгдэл	-101,856,141.36	-169,334,629.18
39217	Ном	8,695,150.00	8,695,150.00
393	Биет бус хөрөнгө	9,773,100.00	84,685,800.00
39301	Програм хангамж	4,377,723.25	4,377,723.25
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,690,223.25	-3,252,723.25
39303	Бусад биет бус хөрөнгө	8,085,600.00	83,560,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,612,387,384.59	7,830,074,816.37
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,612,387,384.59	7,830,074,816.37
51	Засгийн газрын хувь оролцоо	6,612,387,384.59	7,830,074,816.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,980,744,227.75	1,980,744,227.75
51101	Өмч: - төрийн	1,980,744,227.75	1,980,744,227.75
512	Хуримтлагдсан үр дүн	2,453,030,773.97	3,672,739,506.10
51210	Өмнөх үеийн үр дүн	2,453,030,773.97	2,455,052,074.32
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,217,687,431.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,178,612,382.87	2,176,591,082.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,612,387,384.59	7,830,074,816.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,429,147,747.79	3,440,956,529.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,014,680,447.79	1,933,273,189.33
120	Нийтлэг татварын бус орлого	1,014,680,447.79	1,933,273,189.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,014,680,447.79	1,933,273,189.33
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,513,120.00	9,504,722.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	42,113,300.00	120,390,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	966,054,027.79	1,803,378,467.33
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,414,467,300.00	1,507,683,340.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,115,000.00	40,885,840.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,445,000.00	4,365,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,670,000.00	31,670,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,850,840.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,375,352,300.00	1,466,797,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,375,352,300.00	1,466,797,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,000,191,395.03	2,223,104,097.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,000,191,395.03	2,223,104,097.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,892,862,223.63	2,023,467,839.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799,061,978.60	778,928,151.15
210101	Үндсэн цалин	612,712,790.60	509,357,738.15
210102	Нэмэгдэл	121,163,009.00	121,422,950.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,063,000.00	52,033,000.00
210104	Урамшуулал	29,135,240.00	88,155,688.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,987,939.00	7,958,775.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,320,833.81	92,216,879.90
210201	Тэтгээрийн даатгал	58,013,408.81	61,722,684.27
210202	Тэтгэмжийн даатгал	5,242,180.00	7,323,136.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,129,904.00	5,801,389.41
210204	Ажилгүйдлийн даатгал	12,363,474.00	1,407,335.90
210205	Эрүүл мэндийн даатгал	17,571,867.00	15,962,333.71

**Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,109,950.00	97,739,261.00
210301	Гэрэл, цахилгаан	6,883,326.00	10,233,392.00
210302	Түлш, халаалт	84,014,941.00	83,221,200.00
210303	Цэвэр, бохир ус	3,211,683.00	4,284,669.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,230,880.00	58,229,955.00
210401	Бичиг хэрэг	17,261,442.00	19,258,520.00
210402	Тээвэр, шатахуун	27,999,185.00	29,129,290.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,470,253.00	8,339,001.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,363,144.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	140,000.00
2105	Нормативт зардал	1,416,395.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,416,395.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,605,840.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,090,000.00	00.00
210604	Урсгал засвар	10,515,840.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	10,000,000.00	13,000,000.00
210702	Дотоод албан томилолт	10,000,000.00	13,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,828,754.00	119,678,952.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,587,600.00	115,645,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	448,270.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	347,154.00	193,856.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	121,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	770,726.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	724,287,592.22	863,674,639.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	167,909,822.00	229,168,446.98
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	556,377,770.22	634,506,192.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,329,171.40	199,636,258.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,923,800.00	12,671,826.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	100,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,268,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,555,000.00	12,671,826.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	88,405,371.40	186,964,432.45

**Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,405,371.40	186,964,432.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>428,956,352.76</u>	<u>1,217,852,431.86</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	743,570,613.00	165,000.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	743,570,613.00	165,000.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-743,570,613.00	-165,000.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-314,614,260.24</u>	<u>1,217,687,431.78</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,484,893,720.00</u>	<u>1,637,578,062.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,626,420.00	129,894,722.00
120	Нийтлэг татварын бус орлого	48,626,420.00	129,894,722.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,626,420.00	129,894,722.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,513,120.00	9,504,722.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	42,113,300.00	120,390,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,436,267,300.00	1,507,683,340.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,915,000.00	40,885,840.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,445,000.00	4,365,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,470,000.00	31,670,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,850,840.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,375,352,300.00	1,466,797,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,375,352,300.00	1,466,797,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,474,528,720.00</u>	<u>1,596,978,062.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,474,528,720.00	1,596,978,062.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,366,854,548.60	1,397,213,629.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799,600,887.60	779,347,256.15
210101	Үндсэн цалин	438,679,894.60	476,935,931.86
210102	Нэмэгдэл	190,667,052.00	139,799,627.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	69,112,705.00	50,152,480.00
210104	Урамшуулал	55,781,236.00	74,129,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	45,360,000.00	38,330,017.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,423,105.00	91,204,294.40

**Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	70,706,584.00	63,661,489.17
210202	Тэтгэмжийн даатгал	6,735,558.00	6,849,379.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,897,926.00	5,435,825.46
210204	Ажилгүйдлийн даатгал	1,312,933.00	1,340,529.41
210205	Эрүүл мэндийн даатгал	13,770,104.00	13,917,071.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,363,950.00	97,699,261.00
210301	Гэрэл, цахилгаан	6,883,326.00	9,893,685.00
210302	Түлш, халаалт	84,268,941.00	83,181,200.00
210303	Цэвэр, бохир ус	3,211,683.00	4,624,376.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,900,000.00	45,291,001.00
210401	Бичиг хэрэг	10,800,000.00	15,950,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00	12,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,600,000.00	8,361,001.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,612,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	7,368,000.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,169,800.00	13,489,000.00
210604	Урсгал засвар	11,169,800.00	13,489,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,000,000.00	13,000,000.00
210702	Дотоод албан томилолт	10,000,000.00	13,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,807,154.00	122,747,817.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,566,000.00	117,098,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	448,270.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	347,154.00	326,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	166,647.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	1,087,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	216,589,652.00	233,435,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	216,589,652.00	231,435,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,674,171.40	199,764,432.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,268,800.00	12,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	12,800,000.00

**Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	88,405,371.40	186,964,432.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,405,371.40	186,964,432.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>10,365,000.00</u>	<u>40,600,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,365,000.00	40,600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,365,000.00	40,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,365,000.00	40,600,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,365,000.00	40,600,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-10,365,000.00</u>	<u>-40,600,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,980,744,227.75	2,178,612,382.87	2,767,645,034.21	6,927,001,644.83
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,980,744,227.75	2,178,612,382.87	2,767,645,034.21	6,927,001,644.83
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-314,614,260.24	-314,614,260.24
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,980,744,227.75	2,178,612,382.87	2,453,030,773.97	6,612,387,384.59
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,980,744,227.75	2,178,612,382.87	2,453,030,773.97	6,612,387,384.59

**Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,021,300.35	2,021,300.35
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,980,744,227.75	2,176,612,382.87	2,455,052,074.32	6,614,408,684.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-2,021,300.35	00.00	-2,021,300.35
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,217,687,431.78	1,217,687,431.78
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,980,744,227.75	2,176,591,082.52	3,672,739,506.10	7,830,074,816.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,597,156,900.00	1,414,578,629.55	182,578,270.45	88.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,597,156,900.00	1,414,578,629.55	182,578,270.45	88.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,584,356,900.00	1,401,778,629.55	182,578,270.45	88.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл үрэмшил	919,032,600.00	779,347,256.15	139,685,343.85	84.8
210101	Үндсэн цалин	523,791,000.00	476,935,931.86	46,855,068.14	91.1
210102	Нэмэгдэл	199,792,400.00	139,799,627.29	59,992,772.71	70.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,960,000.00	50,152,480.00	25,807,520.00	66.0
210104	Үрэмшлүүлэл	74,129,200.00	74,129,200.00	0.00	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	45,360,000.00	38,330,017.00	7,029,983.00	84.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,145,800.00	91,204,294.40	30,941,505.60	74.7
210201	Тэтгэврийн даатгал	85,954,500.00	63,661,489.17	22,293,010.83	74.1
210202	Тэтгэмжийн даатгал	9,047,700.00	6,849,379.21	2,198,320.79	75.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,238,300.00	5,435,825.46	1,802,474.54	75.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,809,600.00	1,340,529.41	469,070.59	74.1
210205	Эрүүл мэндийн даатгал	18,095,700.00	13,917,071.15	4,178,628.85	76.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,290,600.00	97,699,261.00	9,591,339.00	91.1
210301	Гэрэл, цахилгаан	16,389,000.00	9,893,685.00	6,495,315.00	60.4
210302	Түлш, халаалт	83,181,200.00	83,181,200.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	7,720,400.00	4,624,376.00	3,096,024.00	59.9
2104	Хангамж, бараа материалын зардал	46,962,000.00	45,291,001.00	1,670,999.00	96.4
210401	Бичиг хэрэг	15,950,000.00	15,950,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00	12,000,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,032,000.00	8,361,001.00	1,670,999.00	83.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөрөгчдийн устгал, ариутгал	1,612,000.00	1,612,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,368,000.00	7,368,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0

**Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,489,000.00	53,489,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	53,489,000.00	53,489,000.00	0.00	100.0
2107	Томилголт, зочны зардал	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилголт	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,436,900.00	122,747,817.00	689,083.00	99.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	117,100,000.00	117,098,000.00	2,000.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	448,270.00	201,730.00	69.0
210804	Тээврийн хэрэгслийн татаар	326,900.00	326,900.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	160,000.00	121,000.00	39,000.00	75.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	200,000.00	166,647.00	33,353.00	83.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	1,087,000.00	413,000.00	72.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	198,000,000.00	198,000,000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	198,000,000.00	198,000,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,800,000.00	12,800,000.00		###
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,800,000.00	12,800,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,800,000.00	12,800,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,597,156,900.00	1,414,578,629.55	182,578,270.45	88.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,466,797,500.00	1,284,683,907.55	182,113,592.45	87.6
132001	Орон нутгийн төсвөөс	1,466,797,500.00	1,284,683,907.55	182,113,592.45	87.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	130,350,400.00	129,894,722.00	464,678.00	99.6
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,989,400.00	9,504,722.00	464,678.00	95.3
1E+06	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	120,390,000.00	120,390,000.00	0.00	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	61	57	04	93.4
620001	Удирдах ажилтан	14	13	01	92.9
620002	Гүйцэтгэх ажилтан	22	19	03	86.4
620003	Үйлчлэх ажилтан	16	16	00	100.0
620004	Гэрээт ажилтан	09	09	00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,915,000.00	40,885,840.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,915,000.00	40,885,840.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,915,000.00	36,035,000.00

**Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,915,000.00	36,035,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,915,000.00	36,035,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	4,850,840.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		4,850,840.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60,915,000.00	40,885,840.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,915,000.00	40,885,840.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,445,000.00	4,365,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөөт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,470,000.00	31,670,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,850,840.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Тус газар нь "Төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах, хяналт шинжилгээ хийх, Засаг даргын бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах, захиргааны болон төсөв, татвар, санхүүгийн удирдлага зохион байгуулалтыг хангах, холбогдох байгууллага, иргэдэд мэдээлэл өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх." гэж тодорхойлсон байна.

Нийслэлийн Багахангай дүүргийн ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- УИХ, Засгийн газрын хууль, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж хяналт тавих;
- Тамгын газар дүүргийн төр, захиргааны байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
- Төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, төрийн албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах;
- Тамгын газрын хэлтсүүдийн ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдах;
- Засаг даргын бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангахад чиглүүлж, холбогдох байгууллагуудтай нягт уялдаатай хамтран ажиллах;

2022 онд "Эрүүл иргэн-Хариуцлагатай дүүрэг" зорилт дэвшүүлэн ажилласан байна. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 143 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тус байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, заавар журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд дүүргийн дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийж И баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй асуудалд зөвлөмж өгсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,217,687.4 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	1,198.0	-	(1,198.0)
Бараа материал	86,283.0	95,861.1	9,578.2
Үндсэн хөрөнгө	6,524,906.4	7,734,213.7	1,209,307.3
Нийт хөрөнгө	6,612,387.4	7,830,074.8	1,217,687.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,612,387.4	7,830,074.8	1,217,687.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,612,387.4	7,830,074.8	1,217,687.4

Дээрх хүснэгтээс харахад өмнө оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгө, бараа материал, эздийн өмчийн дансдад өөрчлөлт гарсан байна.

Авлага данс үлдэгдэлгүй болсон нь өмнөх оны авлага барагдснаас шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 95,861.1 мянган төгрөг болж 9,578.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлан онд 164,352.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авснаас зарцуулаагүй үлдэгдэл байгаагаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,830,074.8 мянган төгрөг болж, 1,217,687.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 2-р хорооны авто зам, дугуйн зам, ойн сан бүхий газар, усан бассейн, боулингийн төв барих газрыг бүртгэсэн нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,830,074.8 мянган төгрөг болж 1,217,687.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хуримтлагдсан үр дүн нэмэгдснээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,910,035.1 мянга, нийт зарлагыг 1,910,035.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 651,659.6 мянган төгрөгөөр бууруулж 1,258,375.5 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 290,226.3 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 37,203.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 60,131.0 мянга, хангамж бараа материалын зардлыг 20,117.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 45,051.0 мянга, томилолт зочны зардлыг 44,838.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 88,821.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 60,300.0 мянга, урсгал шилжүүлгийн зардлыг 5,000.0 мянга, нийт 651,689.6 мянган төгрөгөөр бууруулж, нормативт зардлыг 30.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Тайлант онд төсөвт тодотгол хийж зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,597,156.9 мянган төгрөг болгож төсвийг 338,781.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ. Үүнд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 166,840.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 20,599.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 40,160.4 мянга, хангамж бараа материалын зардлыг 12,381.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 45,500.0 мянга, томилолт зочны зардлыг 5,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 10,500.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 35,000.0 мянга, урсгал шилжүүлгийн зардлыг 2,800.0 мянга, нийт 338,781.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,466,797.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 9,969.4 мянга, урьд оны үлдэгдлээс 120,390.0 мянга нийт 1,597,156.9 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны зардалд 1,414,578.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 182,578.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,414,578.6 мянган төгрөг буюу 88.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 139,685.3 мянга, ажил олгогчоос

нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 30,941.5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,591.3 мянга, хангамж, бараа материалын зардлыг 1,671.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлыг 689.1 мянга, нийт 182,578.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Нийт	1,597,158.9	1,414,578.6	182,578.3	88.6%
1.	Хөтөлбөр-70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	1,541,158.9	1,358,578.6	182,578.3	88.6%
2.	Хөтөлбөр-70106 арга хэмжээ 80101 үндсэн үйл ажиллагаа	1,092,703.9	945,417.3	147,286.6	86.5%
3.	Хөтөлбөр-70106 арга хэмжээ 80106 баг хорооны ҮАЗардал	235,053.0	199,761.3	35,291.7	85.0%
4.	Хөтөлбөр-70106 арга хэмжээ 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	12,800.0	12,800.0	0.0	100%
5.	Хөтөлбөр-70106 арга хэмжээ 81102 орон нутгийн нөөц хөрөнгө	150,000.0	150,000.0	0.0	100%
6.	Хөтөлбөр-70106 арга хэмжээ 81560 Монголын улаан загалмай нийгэмлэгээр гэрээгээр гүйцэтгүүлэх	20,000.0	20,000.0	0.0	100%
7.	Хөтөлбөр-70106 арга хэмжээ 83113 татвар хураалтын орлого бүрдүүлэлт	27,000.0	27,000.0	0.0	100%
8.	Хөтөлбөр-70106 арга хэмжээ 83115 Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	3,600.0	3,600.0	0.0	100%
9.	Хөтөлбөр-72208 Ахмад настны хөгжил хамгаалал	56,000.0	56,000.0	0.0	100%
10.	Хөтөлбөр-72208 арга хэмжээ 80103 гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	56,000.0	56,000.0	0.0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансанд дүүргийн иргэдээс өвсний үнийн хандивт 4,365.0 мянга, байрны түрээсийн төлбөрт 4,850.8 мянга, дүүргийн ИТХ-аас 6,670.0 мянга, Нийслэлийн ЗДТГ, захирагчийн албанаас 4,300.0 мянга, УБ НТГ-аас 20,700.0 мянга, нийт 40,882.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, ахмад олон ХБИ унааны нөхөн олговорт 20,700.0 мянга, хамтарсан багийн үйл ажиллагаанд 6,670.0 мянга, өвс тэжээл худалдан авахад 4,365.0 мянга, цэргийн штабын албан хэрэгцээнд 3,000.0 мянга, шагналд 1,300.0 мянга, нийт 36,035.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,850.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагаа, бараа материалд тавих дотоод хяналтыг сайжруулах, элэгдлийн зардал тооцох, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн хэлтсийн ахлах аудитор М.Ундармаа, аудитор Д.Нарантуяа нар гүйцэтгэж, хяналтыг хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2023 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 4/71 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн тайлангийн зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 2,000,191.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 30,002.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж өмнөх оноос нийт зардал 222,812.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн 2022 оны нийт зардлын 2,223,104.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 33,346.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага тайлант онд орон тоо дутуу ажилласантай холбоотой цалингийн зардлыг 139,685.3 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 30,941.5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,591.3 мянга,

хангамж, бараа материалын зардлыг 1,671.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 689.1 мянга, нийт 182,578.2 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Монгол улсын Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад Нержформ ХХК компаниас 18,000.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төрийн хэмнэлтийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.", 14.4. "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын нь 2022 онд нийт 1,466,042.3 мянган төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,333,354.1 мянган төгрөгийн 117 мэдээллийг байршуулж, 5 саяас дээш 132,688.1 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээг дутуу оруулж, 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 132,688.1 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээг дутуу оруулж 2 мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны

тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ." заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомж болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ болон бусад хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 263.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 5 зөвлөмж өгч биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад бараа материалын тайланг зөрүүтэй илэрхийлсэн, шилэн дансны мэдээлэл дутуу зэрэгт зөвлөмж өгсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7,305.7 мянган төгрөгийн акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	372.3	1	372.3	100%
Албан шаардлага	1	6,352.5	1	6,352.5	100%
Зөвлөмж	1	580.9	1	580.9	100%
Нийт дүн		7,305.7		7,305.7	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар ЗДТГ-ын нэмэлт дансанд оруулж байгаа түрээсийн орлогыг гэрээтэй тулган үзэх болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,754.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,754.6 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг э тайлантай тулган шалгахад үр дүнгийн тайлангийн өмнөх оны орлого 1,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;

Аудитаар нийт 56,112.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

Цалингийн дэлгэрэнгүй бүртгэл, тушаал шийдвэрийг тулган шалгахад 11 дүгээр сард дүүргийн Засаг даргын захирамж, Тамгын газрын тушаалаар нийт 39 ажилтанд нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний шагнал, урамшууллыг хавтгайруулан олгож төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1058 тоот тушаалаар баталсан орон тоог зөрчин зөвлөх ажиллуулж 18,596.6 мянган төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн байна.

Засаг даргын нөөц сангийн зардлыг тулган шалгахад жил бүр болдог санхүүчдийн өдөр, архивчдын өдөр, багш нарын баяр зэрэг тэмдэглэлт өдрийн арга хэмжээнд 7,558.0 мянга, ЗДТГ-ын 2 ажилтанд буцалтгүй тусламж 1,000.0 мянга, нийт 8,558.0 мянган төгрөгийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжтой зардлыг санхүүжүүлсэн нь Сангийн сайдын баталсан 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 "энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ" заалттай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэхгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал:

1 Илрүүлэлт: Бараа материалын тайланг тулган шалгахад бараа материалыг улирлаар өссөн дүнгээр тайлагнасан, дансны ангилал тус бүрээр бүртгээгүй, бусад хангамж, бичиг хэргийн материалын эхний үлдэгдлийг 5,738.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдаа нь бараа материалд тавих хяналт сулрах, тайланд зөрүүтэй тусгагдах эрсдэлд хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн.

2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж, бараа материалыг үнэн зөв тайлагнах;

5.2.2 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал:

1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс хөрөнгийг тулган шалгахад тоног төхөөрөмжийн ашиглах жилийг буруу тооцсноос 16.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу илэрхийлэгдсэн алдаа нь зардал буруу тайлагнах эрсдэлд хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн.

2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж, элэгдлийн зардлыг залруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгажгүй оривдуулсан		Буруу тусгаж илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Загруулсан		Загруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Тр дүнгийн тайлангийн өмнөх оны орлогыг дутуу тайлагнасан	1	1,000.0	-	-	1	1,000.0	1	1,000.0	-	-	-	-
Борлоо материалыг улирлаар өссөн дүнгээр тайлагнасан дансны ангилал зөрүүтэй	1	5,738.0	-	-	1	5,738.0	-	-	1	5,738.0	1	5,738.0
Үндсэн хөрөнгийн эцсийн жилийг буруу тооцон элэгдлийн зардалыг дутуу тайлагнасан	1	16.6	1	16.6	-	-	-	-	1	16.6	1	16.6
Дүн	3	6,754.6	1	16.6	2	6,738.0	1	1,000.0	2	5,754.6	2	5,754.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Ажилтнуудад шагнал урамшууллыг хавтгайруулан олгосон	1	28,957.6	-	-	1	28,957.6	-	-	-	-	-	-
Засаг даргын нөөц хөрөнгийн журмыг зөрчин төлөвлөж болох зардлыг санхүүжүүлсэн	1	8,558.0	-	-	1	8,558.0	-	-	-	-	-	-
Зөвлөхийн орон тоо илүү ажиллуулж цалин олгосон	1	18,596.6	-	-	1	18,596.6	-	-	-	-	-	-
Дүн	3	56,112.2	-	-	3	56,112.2	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд зарим мэдээллийг дутуу байршуулсан.	1	132,688.1	-	-	-	-	1	132,688.1
Дүн	1	132,688.1	-	-	-	-	1	132,688.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн хуулийн 14.1, 14.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй.	1	18,000.0	-	-	-	-	1	18,000.0
Дүн	1	18,000.0	-	-	-	-	1	18,000.0
Нийт дүн	2	150,688.1	-	-	-	-	2	150,688.1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Сойлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2023.02.24 № 140
танай _____-ны № _____-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Л.САНЖИЙЖАМЦ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар 56,112.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлагыг хүргүүлж байна

Албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002031349



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 112/А023078

Улаанбаатар хот

10785-2023/01/118-СТБ-ТМД

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар даргах зөрчил илэрлээ.Үүнд:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1058 тоот тушаалаар баталсан орон тоог зөрчин зөвлөх ажиллуулж 18,596,600.00(арван найман сая таван зуун ерэн зургаан мянга зургаан зуун) төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.4. "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан,зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал". гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Зөвлөх ажиллуулж 18,596,600.00(арван найман сая таван зуун ерэн зургаан мянга зургаан зуун) төгрөгийн цалин олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт[1] ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Багахангай дүүргийн дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Санжийжамц, ерөнхий нягтлан бодогч С.Баасанхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

АУДИТОР

Д.НАРАНТУЯА

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙСЛЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР

З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр Дугаар 113 / АУД/2017
Нийт - 2023/08 / 112 - Сп - 753

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Цалингийн дэлгэрэнгүй бүртгэл, тушаал шийдвэрийг тулган шалгахад тайлант онд дүүргийн Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалаар 39 ажилтанд нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний нийт 28,957,603.00 (хорин найман сая есөн зуун тавин долоон мянга зургаан зуун гурван) төгрөгийн шагнал урамшууллыг хавтгайруулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад зох зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.4. "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал". гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Ажилтнуудад 28,957,603.00 (хорин найман сая есөн зуун тавин долоон мянга зургаан зуун гурван) төгрөгийн шагнал урамшуулал олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт [1] ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Багахангай дүүргийн дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Санжийамц, ерөнхий нягтлан бодогч С.Баасанхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

АУДИТОР

Д.НАРАНТУЯА

ХЯНАСАН:

САНХҮҮ НИЙЦЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА АУДИТЫН МЕНЕЖЕР

З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 97 / 1627078

Улаанбаатар хот

1175-2023/08/18-СН-ТШ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар даргах зөрчил илэрлээ.Үүнд:

Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг тулган шалгахад жил бүр болдог санхүүчдийн өдөр, архивчдын өдөр, багш нарын баяр зэрэг тэмдэглэлт өдрийн арга хэмжээнд 7,558,000.00 төгрөг, Засаг даргын тамгын газрын 2 ажилтанд буцалтгүй тусламж 1,000,000.00 төгрөг, нийт 8,558,000.00(найман сая таван зуун тавин найман мянган) төгрөгийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжтой зардлыг санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"заалт, Сангийн сайдын баталсан 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт,зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 "энэ журмын 2.1.1,2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.4. "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан,зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс 8,558,000.00(найман сая таван зуун тавин найман мянган) төгрөгийн урьдчилан төлөвлөж болох зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт[1] ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Багахангай дүүргийн дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Санжийжамц, ерөнхий нягтлан бодогч С.Баасанхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

АУДИТОР

ХЯНАСАН:

Д.НАРАНТУЯА

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР

З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ